

Нийслэл дахь гэмт хэргийн төлөв байдал, хандлага

Д. Дашижав

Нийслэлийн засаг даргын

Статистик, мэдээлэл, судалгааны

албаны мэргэжилтэн

1. Гэмт явдал, гэмт хэрэг, үндсэн шинж

Зах зээлийн харилцаанд шилжиж байгаа өнөө үед нийгэм, улс төр, эдийн засгийн хөгжлийн үйл явц, түүний хүрээнд гарч байгаа хүний амьдрал, түүний ахуй нөхцөлтэй холбоотой олон асуудалд шүүмжлэлтэй хандах, өөрөөр сэтгэж бодохыг зүй ёсоор шаардаж байна. Тийм асуудлын нэг нь хүн төрлөхтнийг олон зууны турш бухимдуулж ирсэн гэмт явдал юм. Аливаа нийгэм гэмт явдлыг өөрөө төрүүлдэг боловч түүнтэйгээ эргэж тэмцэхээс өөр аргагүйд хүрдэг байна. Хүний нийгмийн оршиж, тогтох ирсэн бодит зүй тогтол түүх ийм юм.

Гэмт явдал бол нийгэм өөрөө хэдий хэр оршин тогтнож ирсэн төдий хэр хугацаанд хүн төрлөхтнийг дагаж ирсэн нийгмийн сөрөг үзэгдэл юм. Хүмүүс олон зуун жилийн турш гэмт явдлын өмнө айж түгшиж, бухимдаж ирсэн ба гэмт хэрэг хаанаас гарч ирэв, түүнтэй хэрхэн тэмцэх ёстой юм бэ гэдэг асуулт байнга тавигдсаар ирсэн байна.

Гэмт явдлын түүхэн хандлага, түүнд хийсэн судалгаа олон зуун жилийн тэмцлийн арга, туршлагаас үзэхэд гэмт хэргийг нийгмийн хөгжлийн зөрчлийн сөрөг үр дагавар болж илэрдэг нийгэм, улс төр, эдийн засгийн бүх хэлбэршилд байдаг бодит үзэгдэл гэж үзэж болох юм. Энэ учраас гэмт явдлыг нийгмийн ухамсын холбогдолтой бүх талаар нөхцөлдсөн, түүнтэй салшгүй уялдаа холбоотой нийгмийн нарийн төвөгтэй сөрөг үзэгдэл гэж нэрлэж болно.

Гэмт хэрэг гэдэг нь Монгол улсын тусгаар тогтийн бүрэн эрхт болон үндэсний аюулгүй байдал, хүний амь, эрүүл мэнд, эрх чөлөө, нийгмийн болон хувийн өмч, үндэсний баялаг, байгаль орчин, түүний эрх зүйн бусад журамд халдаж хохирол учруулсан, эсхүл учруулах агуулгатай нийгэмд аюултай, эрүүгийн хуульд заасан гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүй юм. Гэмт хэрэг нь нийгэмд аюултай, эрүүгийн хуульд заасан, гэм буруутай, ял хүлээх гэсэн хэд хэдэн заавал байх шинжтэй.

а. Гэмт хэрэг нийгэмд аюултай байх шинж:

Гэмт хэрэг нь ямагт хүний идэвхтэй буюу идэвхгүй зан үйлийн хэлбэрээр илэрдэг гэмт үйл ажиллагаа байдаг. Гэм буруутай этгээдийн үйлдэл, эс

Үйлдэл заавал нийгэмд аюултай байх нь гэмт хэргийн хамгийн гол материяллаг шинж юм. Гэмт үйлдэл, эс үйлдлийн нийгэмд аюултай шинж нь эрүүгийн хуулийн хэм хэмжээгээр хамгаалагдсан нийгмийн харилцаанд бодоит хохирол учруулсан, эсвэл тийм хор уршиг учрах бодит боломж бий болгосоноор илэрнэ.

6. Гэмт хэргийн хуульд заасан шинж:

Гэм буруутай этгээдийн хийсэн үйлдэл, эс үйлдэл нь нийгэмд аюултай байлаа ч тухайн үед эрүүгийн хуульд заагаагүй бол гэмт хэрэг болохгүй. Иймд үйлдэл, эс үйлдлийг эрүүгийн хуульд гэмт хэрэг гэж заасан байх нь гэмт хэргийн нөгөө нэг зайлшгүй шинж болдог.

в. Үйлдэл, эс үйлдэл гэм буруутай байх гэмт хэргийн шинж:

Гэмт хэргийн нийгэмд аюултай, хуульд заасан хоёр шинж шийдвэрлэх ач холбогдолтой гэм буруутай этгээд өөрийн хийх гэж буй үйлдэл, эс үйлдэл түүний улмаас үүсч болох хор уршигт сэтгэл зүйн хувьд хэрхэн хандсан бодит байдлыг заавал тогтоох шаардлагатай байдал.

Манай эрүүгийн хуульд заасан үйлдэл, эс үйлдлийг субъект оюун санаа хүсэл зоригийн дараах байдлуудад байхдаа хийсэн байвал түүнийг сая гэм буруутай гэж үзнэ. Үүнд:

1. Шууд санаатай, гэмт хэрэг үйлдсэн этгээд өөрийн үйлдэл бусад эс үйлдлийн нийгэмд аюултай шинж чанарыг ухамсарлаж түүнээс учирч болох нийгэмд аюултай хор уршигийг урьдаас мэдсээр байж хүсэж үйлдсэн

2. Шууд бус санаатай үйлдэл, эс үйлдлийнхээ төлөө нийгэмд аюултай хор уршигийг ухамсарлаж, мэдэж байсан боловч хор уршигт зориуд хүргэсэн. Хөнгөмсөгөөр хандсан гэмт хэрэг үйлдсэн этгээд өөрийн үйлдэл буюу эс үйлдэл нийгэмд аюултай хор уршигт хүргэж болохыг урьдаас мэдсэн боловч тэр хор уршигийг гаргахгүй байж чадна гэж хөнгөмсөгөөр найдаж хор уршиг бий болгосон.

3. Хайхрамжгүй хандсан үйлдэл, эс үйлдлийнхээ улмаас хор учруулна гэдгийг урьдаас мэдэх ёстой, мэдэх бололцоотой байсан атал мэдэлгүй үйлдсэн гэмт хэрэг үйлдсэн этгээд хэрэг үйлдэх үеийн нөхцөл байдал, үйлдэл эс үйлдлийн нийгэмд аюултай шинж түүнээс учрах хор уршигийг урьдаас мэдэх боломжгүй, мэдэх үүрэгтгүй байсан нь түүнийг гэм буруугүйд тооцох үнэслэл болно.

Орчин үед гэмт явдлыг шинжлэх ухааны үндэстэй судлах, түүний үр дүнг ашиглах явдал тулгамдсан чухал зорилт болж байна. Ийм нөхцөлд гэмт хэрэгтэй тэмцэхэд яаж хандах вэ, ямар арга замаар явуулах вэ гэдэг асуулт зүй ёсоор анхаарал татаж байна.

Энэ талаар орчин үед хоёр хандлага байна. Нэгдэх нь гэмт явдал нийгмийн үзэгдэл учир тэр гардаг жамаараа гарна, түүнтэй тэмцээд үр дүнд хүрэхгүй гэж үздэг.

Хоёрдахь нь гэмт хэрэг хэдийгээр өөрийн зүй тогтолтой ч гэсэн түүнтэй тэмцэх ажлыг идэвхтэй, эрчимтэй явуулж чадвал түүнийг устгаж, арилгаж тэмцэх ажлыг идэвхтэй, эрчимтэй явуулж чадвал түүнийг бухимдуулахгүй байлгаж болох ба цаашид бууруулж, цөөрүүлж болно гэж үзэж байна.

Дэлхийн ихэнх орон хоёр дахь үзэл баримтлалаар ажиллаж байгаа ба манай оронч энэ замаар явж байгаа билээ.

2. Нийслэл дэх гэмт хэргийн өнөөгийн байдал

Нийслэл Улаанбаатар хотод 1990 онд 2884 гэмт хэрэг гарч байсан бол 1996 онд 9917 гэмт хэрэг гарч даруй 3.4 дахин нэмэгдэв.


Гэмт хэргийн илрүүлэлт 1990 онд 74.8 хувь байсан бол 1996 онд 72.6 хувь болж 2.2punktээр доогуур байна.

Хүснэгт 1. Улаанбаатарт гарсан гэмт хэрэг 1990–1996

| Он | 1990 | 1991 | 1992 | 1993 | 1994 | 1995 | 1996 |
|-----------------------------|------|------|------|------|------|------|------|
| Гарсан гэмт хэрэг–бүгд | 2884 | 3581 | 4722 | 7089 | 7986 | 9217 | 9917 |
| Бусдыг санаатай алсан | 20 | 29 | 49 | 82 | 86 | 74 | 57 |
| Хүчин | 134 | 130 | 135 | 139 | 144 | 140 | 138 |
| Танхай | 187 | 288 | 334 | 370 | 527 | 536 | 657 |
| Дээрэм | 102 | 119 | 117 | 185 | 243 | 279 | 325 |
| Иргэний эрүүл мэндийн эсрэг | 341 | 283 | 316 | 351 | 490 | 554 | 673 |
| Иргэдийн өмчийн хулгай | 1078 | 1426 | 2163 | 3480 | 3932 | 4624 | 4384 |
| Аж ахуйн өмчийн хулгай | 271 | 482 | 720 | 1085 | 828 | 966 | 1276 |
| Булаалт | 133 | 94 | 96 | 122 | 142 | 157 | 181 |
| Зам, тээврийн хэрэг | 245 | 276 | 328 | 378 | 380 | 513 | 588 |
| Гал түймрийн хэрэг | 20 | 12 | 9 | 9 | 16 | 19 | 15 |
| Бусад | 353 | 442 | 455 | 897 | 1198 | 1355 | 1623 |

1996 онд согтуугаар үйлдэгдсэн 1604, бүлгээр үйлдсэн 929 хэрэг гарсан нь өмнөх оныхоос 12.0–20.3 хувиар нэмэгджээ. Олон нийтийн газарт гарсан хэрэг өмнөх оныхоос 8.2 хувь, гэр орон сууцанд гарсан хэрэг 0.4 хувиар буурсан байна.


Гэмт хэрэг нь ялангуяа хүний идэвхтэй буюу ялангуяа зан шийдвэрийн хэлбэрээр илэрдэг гэмт дэх хандлага байдаг. Гэм буурутай эзэмшийн үйлдэл, эс



Хүснэгт 2. Дүүрэгт гарсан гэмт хэрэг, төрлөөр, 1996

| Дүүрэг | Бүгд | Бусдын амийг хорлосон | Хүчин | Танхай | Иргэдийн өмчийн хулгай | Аж ахуйн өмчийн хулгай | Зам тээврийн хэрэг |
|----------------|------|-----------------------|-------|--------|------------------------|------------------------|--------------------|
| Багануур | 422 | 1 | - | 36 | 112 | 112 | 9 |
| Багахангай | 96 | - | 1 | 15 | 32 | 36 | - |
| Баянгол | 1862 | 4 | 32 | 107 | 731 | 225 | 109 |
| Баянзүрх | 1450 | 12 | 26 | 105 | 634 | 169 | 102 |
| Сонгинохайрхан | 1551 | 7 | 23 | 96 | 837 | 218 | 98 |
| Сүхбаатар | 1266 | 10 | 12 | 65 | 498 | 132 | 126 |
| Хан-Уул | 906 | 11 | 17 | 74 | 299 | 220 | 51 |
| Налайх | 179 | 2 | 6 | 19 | 44 | 34 | 9 |
| Чингэлтэй | 2185 | 10 | 21 | 140 | 1197 | 130 | 84 |
| Дун | 9917 | 57 | 138 | 657 | 4384 | 1276 | 588 |

Оны эхний 10000 хүнд ноогдох гэмт хэргийн тоо 1995 оныхоос 1996 онд Чингэлтэй, Баянгол, Сонгинохайрхан, Баянзүрх, Багануур, Багахангай дүүрэгт өссөн нь эдгээр дүүрэгт гэмт хэрэг буурахгүй байгааг харуулж байна



Оны эхний 10000 хүнд ноогдох гэмт хэргийн тоо 1995 оныхоос 1996 онд Чингэлтэй, Баянгол, Сонгинохайрхан, Баянзүрх, Багануур, Багахангай дүүрэгт өссөн нь эдгээр дүүрэгт гэмт хэрэг буурахгүй байгааг харуулж байна.

Хүснэгт 3. 10000 хүнд ноогдох гэмт хэргийн тоо, дүүргээр


| Дүүрэг | 1991 | 1992 | 1993 | 1994 | 1995 | 1996 |
|----------------|------|------|------|------|------|------|
| Багануур | 86 | 110 | 170 | 181 | 200 | 242 |
| Багахангай | 29 | 36 | 39 | 46 | 119 | 171 |
| Баянгол | 53 | 73 | 102 | 118 | 135 | 163 |
| Баянзүрх | 74 | 90 | 131 | 130 | 135 | 140 |
| Сонгинохайрхан | 60 | 77 | 104 | 96 | 118 | 125 |
| Сүхбаатар | 81 | 92 | 108 | 122 | 165 | 151 |
| Хан-Уул | 73 | 99 | 169 | 147 | 198 | 161 |
| Налайх | 54 | 78 | 62 | 63 | 85 | 79 |
| Чингэлтэй | 80 | 100 | 149 | 230 | 245 | 236 |
| Дун | 67 | 85 | 120 | 133 | 155 | 160 |

1996 онд гэмт хэрэг үйлдсэн хүний тоо 1995 оныхоос 10 хувиар өсчээ. Гэмт хэрэг үйлдсэн нийт 7543 хүний 72 хувь буюу 5428 нь ажил сургуульгүй, 8 хувь буюу 632 нь 177 хүртэл насны хүүхдүүд байна. Нийт хэрэг үйлдэгчдийн 8.3 хувь буюу 643 эмэгтэй гэмт хэрэг үйлджээ.

Хүснэгт 4. Гэмт хэрэг үйлдэгчдийн тоо, дүүргээр 1996

| Дүүрэг | Хэрэг үйлдэгчид -Бүгд | Бүлэглэсэн | Согтуурсан | Урьд нь ял шийтгүүлсэн |
|----------------|-----------------------------|------------|------------|---------------------------|
| Багануур | 380 | 162 | 100 | 90 |
| Багахангай | 86 | 13 | 13 | 9 |
| Баянгол | 1066 | 149 | 152 | 79 |
| Баянзүрх | 1366 | 429 | 459 | 124 |
| Сонгинохайрхан | 1049 | 142 | 260 | 95 |
| Сүхбаатар | 1089 | 230 | 332 | 101 |
| Хан-Уул | 738 | 204 | 206 | 79 |
| Налайх | 215 | 101 | 70 | 9 |
| Чингэлтэй | 1584 | 248 | 397 | 118 |
| Дун | 7573 | 1678 | 1989 | 704 |

Гэмт хэрэг үйлдэгчдийн хэлбэр, 1996



1996 онд ууж согтуурсан 52.1 мянган хүнийг эрүүлжүүлсэн нь 1995 оныхօос 14.3 хувиар ёсчээ.

Өнөөдөр нийслэлд өдөрт дунджаар 27 гэмт хэрэг гарч буйн дотор танхай 2, дээрээ 1, иргэний эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг 2, иргэдийн өмчийн хулгай 12, аж ахуйн өмчийн хулгай 3, зам тээврийн хэрэг 2 тус тус гарч 142 хүнийг эрүүлжүүлж байна. Үүний улмаас өдөрт 5 хүн гэмтэж, 1.1 хүн нас барж, 13 сая төгрөгийн хохирол төр, аж ахуйн нэгж, хүн амд учирч байна.

Нийслэл хотод эрүүгийн нөхцөл байдал хүндэрч, гэмт хэрэг нэмэгдэж байгаа нь нийгэм, эдийн засаг, сэтгэл зүйн олон учир шалтгаантай байна.

Хүн амын амьжиргааны түвшин доройтож, ядуурал ихэсч байгаа нь юуны өмнө шилжилтийн үеийн эдийн засгийн уналт, үндэсний үйлдвэрлэлийн зогсолттой холбоотой бөгөөд хүмүүсийн оюуны хоосролт, ёс суртахууны доройтол, гэр бүл салалт, хүүхдийн өнчрөл, гэмт хэрэг өсөх хандлагатай байгаа нь ядуурал, ажилгүйдлийн уршигт үр дагавар болж байна.

Гэмт хэргийн улмаас учирсан хохирол,
дүүргээр 1996

Хүснэгт 5

| Дүүргэг | Нийт хохирол, сая төг | Гэмтэж осолдсон хүн бүгд | Нас барсан хүн |
|----------------|--------------------------|--------------------------------|----------------|
| Багануур | 90.8 | 82 | 23 |
| Багахангай | 34.3 | 4 | - |
| Баянгол | 341.5 | 280 | 66 |
| Баянзүрх | 1120.6 | 422 | 119 |
| Сонгинохайрхан | 477.4 | 319 | 75 |
| Сүхбаатар | 759.1 | 296 | 35 |
| Хан-Уул | 91.9 | 38 | 11 |
| Налайх | 595.2 | 184 | 64 |
| Чингэлтэй | 1265.3 | 246 | 19 |
| Дун | 4776.1 | 1871 | 412 |

Саяхан хийсэн социологийн судалгаанд хамрагсадын 72.4 хувь нь гэмт хэрэг гарах нэг нөхцөл нь ажилгүйдэл, ядуурал, амьдралын доройтол гэж үзжээ.

Өнөөдөр нийслэл хотод хүн амын хэт төвлөрөл бий болсон, улсын ба хувийн өмчид хандах хандлага өөрчлөгдж байгаа нь гэмт хэрэг гархад нөлөөлж байна.

Сүүлийн гурван жилд нийслэл хотод хөдөө орон нутгаас 12444 өрхийн 21266 хүн шилжиж иржээ. Үүнээс гадна албан ёсны зөвшөөрөлгүй ирсэн иргэд, бүх их, дээд сургууль, коллежид суралцахаар элсэгчид, хорих байгууллагаас суллагдсан хүмүүс, ажил, амьдралын бусад шалтгаанаар нийслэл хотод шилжин ирж буй иргэдийн тоо эрс нэмэгдлээ.

1996 онд нийслэл хотод гэмт хэрэгт холбогдогсдын 9.3 хувь нь урьд өмнө ял эдлээд гарсан хүмүүс байгаа нь энэ чиглэлээр тодорхой арга хэмжээ авах шаардлагатайг харуулж байна.

Нийслэл хотын хүн амын механик өсөлт нь засаг захиргааны нэгж, цагдаа, хуулийн байгууллагын нэг амжилтанд оногдох ачааллыг ч нэмэгдүүлж байна. Одоогийн байдлаар орон суудны хорооллын цагдаагийн хэсгийн нэг байцаагчид 1470 өрхийн 13850 иргэн, 23 аж ахуйн нэгж оногдож байна.

Үүнтэй уялдуулан нийслэл хотыг бүс нутгийн бодлогоор, хүн амын хэт өсөлтийг хязгаарлах, дагуул хот, тосгодыг хөгжүүлэх зэрэг хот байгуулалт,

телевлэлтийн бодлоготой холбоотой иж бүрэн шийдвэрлэх асуудал ч зүй ёсоор гарч байна.

Эдийн засаг, нийгмийн дээрх шалтгаанаас үүдэн нийслэл хотын хүн амын зан суртахуун, уламжлалт ёс жаяг, аж амьдралын хэв маягт өөрчлөлт орж байгаа нь гэмт хэрэг гарах, түүний өсөлттэд нөлөөлөх хүчин зүйл болж байна.

Энэ нь хар амиа бodoх, шунхайрах, хөрөнгө мөнгөнний хэт сонирхолд автах, биеийн амрыг хайж хөнгөн хялбар аргаар мөнгө олохыг хүсэх, хээл хахуульд өртөх, хүнлэг энэрэнгүй зан чанар алдагдах зэрэг нийгэм—сэтгэл зүйн олон үр дагавраар илэрч байна.

Үүнтэй уялдуулан өрх гэрийн хүмүүжил, эцэг эхийн үлгэр дуурайдал, хамт олны үүрэг, ахмад үеэ хүндэтгэх уламжлалыг сэргээхэд бүх нийтийн зүгээс хийх ажлыг сайжруулах шаардлагатай байгаа нь судалгаанаас харагдаж байна.

Хүмүүжил, ёс суртахуун, сахилга батын талаар доголдсон үр хүүхэд, ах дүү, ажилтнаа гэр бүл, төрөл төрөгсөд, хамт олны хүрээнд хэлэлцэж зөвлөх, хянаж шаардах, итгэл үнэмшил төрүүлэх, тодорхой ажил үүрэг хүлээлгэх зэргээр хүнтэй ажиллах, хүнд нөлөөлөх талаас ихээхэн ажил хийх, энэ талаар урьд өмнө уламжлагдаж ирсэн ажлын үр нөлөөтэй арга хэлбэрийг сэргээн хөгжүүлэх нь чухал байна.

Гэмт хэргийн шалтгаан нөхцлийг шинжлэх ухааны үндэстэй судалж, түүний мөрөөр гар санаа нэгдэн хамтарч шуурхай ажиллах, төрийн хууль тогтоомжийг сурталчилж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг далайцтай зохион байгуулахад нийслэл, дүүргийн цагдаа, хуулийн байгууллагуудын хамтын ажиллагаа ч чухал юм. Нөгөө талаар эрүү, иргэний аливаа хэрэг асуудлыг богино хугацаанд үнэн зөв шийдвэрлэх, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг түргэн барагдуулах, цагдаа, хуулийн байгууллагын ажилтны зан харьцааны дутагдал доголдлыг арилгаж, тэдний үйл ажиллагааны дайчин шудрага байдлыг сайжруулах нь нийслэл хотод нийгмийн дэг журам бэхжүүлэх нэг хүчин зүйл гэж судалгаанд хамрагсадын олонхи нь үзсэн байна. Энэ бол нийслэлчүүдийн санал, сэтгэл санааны илэрхийлэл юм.

Нийслэлд явуулсан судалгааны дүнгээс үзэхэд цагдаа, замын цагдаагийн газрын ажлыг судалгаанд хамрагдсан таван хүн тутмын нэг нь боломжтой, гурав нь дунд зэрэг, нэг нь хангалтгүй дүн өгчээ. Хот дүүргийн шүүх, прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн байгууллагын ажлыг эрс өөрчлен , тэнд алба ажил хашигчдын хариуцлага санаачилгыг бүх талаар дээшлүүлэх нь чухал байна.

Нийгмийн дэг журмыг бэхжүүлж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг сайжруулахын тулд нийслэлийн төр захиргаа, хууль, цагдаагийн байгууллага, нийт хамт олны хүч анхаарлыг дараах асуудалд төвлөрүүлэх хэрэгтэй байна.

Үүнд:

1. Нийслэлд гарч буй гэмт хэргийн 50 гаруй хувийг эзэлж байгаа хулгайн гэмт хэрэгтэй тэмцэх ажлыг хүчтэй болгох

Хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор албан байгууллага, аж ахуйн нэгжийн харуул манаа, дотоод эмх цэгцийг сайжруулах, дохиоллын системд хамруулан, иргэдээс өмч хөрөнгөө хамгаалах үүргийг дээшлүүх ажлыг дүүрэг, цагдаагийн байгууллагууд нэн дариу хийх нь чухал.

Орон сууцны хороололд орцны эргүүл жижүүр ажиллуулж байгаа нь хулгайн гэмт хэрэг гарахаас урьдчилан сэргийлэхэд чухал ач холбогдолтойг амьдрал харуулж байна. Нийслэлийн хэмжээнд орон сууцны 205 байрны 390 орцонд 1170 хүн эргүүл жижүүрээр ажиллаж байна.

2. Архидан согтуурахтай тэмцье. Нийслэл хотод 1992 онд 16000 хүн эрүүлжигдэж байсан бол 1997 оны эхний найман сард 39 мянга болжээ. Архидан согтуурах, түүнийг байнга буюу хэтрүүлэн хэрэглэх, ухаалаг бус хэрэглээ ч иргэд, ялангуяа хүүхэд, залуучуудын дунд их нэмэгджээ. Эрүүл мэнд цагдаагийн байгууллагын гаргасан судалгаагаар архаг гэгдэх архичид 1900 бүртгэгдэж тогтоогдсон нь 1996 онныхоос бараг хоёр дахин нэмэгджээ. Баар, зоогийн газрын too нийслэлд 435-д хүрсэн нь согтууруулах ундаагаар үйлчлэх, худалдан борлуулахдаа түүнээс олох ашгийг гол сонирхол болгох хандлага газар авч байгааг харуулж байна. Мөн архи, согтууруулах ундаа үйлдвэрлэдэг газар 30 гаруй байна.

3. Авто аваарын хэрэгтэй тэмцье. 1997 оны техникийн үзлэг тооллогоор нийслэлд 35 мянга гаруй тээврийн хэрэгсэл тоологдсон нь 1994 оныхоос 38.2 хувиар нэмэгджээ. Сүүлийн гурван жилд нийслэлд зам тээврийн осол 5689 гарч, 1573 нь эрүүгийн шугамаар шалгагдан, түүний улмаас 230 нь нас барж, 1572 хүн гэмтэж, үлэмж хэмжээний эд материалын хохирол учирчээ. Нийслэлд авто ослын 70 гаруй хувь нь жолоочийн буруугаас шалтгаалсны дотор нийт ослын 60.9 хувийг хэвшлийн автомашины жолооч үйлдэжээ.

4. Хүүхэд залуучуудыг гэмт хэрэг зөрчилд холбогдохоос сэргийлье. Нийслэл хотод 0-15 насны хүүхэд нийт хүн амын 38.9 хувийг эзэлдэг. Нийслэлд нийт гэмт хэрэг үйлдэгсдийн 12 хувийг хүүхдүүд эзэлж байгаа нь анхаарахгүй орхихын аргагүй юм. Хүүхэд залуучууд амиа хорлох явдал ихэсч байна. Хүүхдүүд тэнүүчлэн амьдарч байгаагийн гол шалтгаан нь гэр бүл салалт, эцэг эхийн хүйтэн хайнга харьцаа, дарамт хүчирхийлэл, архидалт, амьдралын ядуурал, сургууль завсардалтаас эх үүсвэртэй байна. Юуны өмнө хүүхдийн төрсөн гэр орных нь нөхцөл өсгөж хүмүүжүүлэх, эцэг эхийн үүрэг хариуцлагыг эрс дээшлүүлэх хэрэгтэй байна.

5. Нийгэм эдийн засгийн тогтвортой бус байдал, амьдралын ядуурал, оюуны хоосрол, ёс суртахууны доройтол зэрэг амьдралын янз бүрийн нөхцөл шалтгаанаас болж охид, эмэгтэйчүүд архидан согтуурах, садар самуун амьдралд татагдаж биэз үнэлэх явдал өсөх хандлагатай багаа нь хамгийн ихээр сэтгэл зовоож байгаа асуудлын нэг мөн. Эрүүл мэндийн

сурталчилгааг өргөн зохиох, иргэнийх нь хувьд захиргааны арга хэмжээ авахаас эхлээд энэ сөрөг үзэгдлийн эсрэг бүх нийтээрээ тэмцэж, таслан зогсоох санал бодлоо ярьцаая.

6. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлье. Энэ талаар тусгайлан хууль боловсруулан гаргах хэрэгтэй байна.

Гэмт хэргийн мэдээ УСГ 1990–1996 он
Ашигласан материал

С. Жанцан, М. Мөнхбаяр " Гэмт хэргийн ойлголт, үндсэн шинж
Монголын төр, эрх зүй 96"1

Гэмт явдалтай тэмцэх онолын асуудалд
Монголын төр, эрх зүй 95"1

Ж. Наранцацралт "Нийгмийн дэг журмыг бэхжүүлж, гэмт хэргээс
урьдчилан сэргийлэх ажилд иргэд,
хамт олны оролцоог өргөжүүлье

Улаанбаатар сонин 1997.9.30 И186